

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2017 оны 01 сарын 18.-ны  
өдөр хүлээн авсан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар A/29, A/12

Улаанбаатар  
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай  
хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 2016 оны 59, А/67 дугаар  
хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусlamж  
үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд  
эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам"-ын дөрөвтдор дурдсан агуулгатай 4.3  
дахь заалт нэмсүгэй:

"4.3. Шаардлагатай тохиолдолд хорих байранд хоригдож буй этгээдэд эмнэлгийн  
тусlamж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад хэвтэн эмчлэх үед цагдаагийн  
байгууллагатай хамтран ажиллаж болно".

2. "Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусlamж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн  
байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх  
 журам"-ын Гуравын 3.3, 3.13-т заасан "Тахарын албаны" гэснийг "Шүүхийн шийдвэр  
гүйцэтгэх байгууллагын" гэж, 3.7, 3.8, 3.10, 3.13-т заасан "Тахарын алба" гэснийг  
"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

3. "Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусlamж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн  
байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх  
 журам"-ын Нэгийн 1.3-д "Тахарын албаны тухай хууль" гэснийг хассугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

